



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А133

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Төрийн үйлчилгээний гавьяат ажилтан Чойжингийн Эрдэнэбаатар, "Зүүн Хүрээ Дашчойлин" хийдийн дэд хамбаар өргөмжлөгдсөн Жонан Ханчэн Гэгээнтэн нарт хүндэтгэл үзүүлэхэд зориулж 4,799,000 (дөрвөн сая долоон зуун ерэн есөн мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



نہ نہ نہ
 نہیں وہ نہیں نہیں

[illegible]

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дүгээр сарын 24 -ний өдрийн
4131 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Мөнгөн аяга	864,500	2 ш	1,729,000
2	Өргөмжлөл	60,000	2 ш	120,000
3	Хүндэтгэл	375,000	2 ш	750,000
4	Гарын бэлэг	500,000	2 ш	1,000,000
5	Уран зураг	600,000	2 ш	1,200,000
	Нийт дүн			4,799,000